



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/226/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: https://audit.mn/?page_id=579 Мөрөн хот 2022 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn Ихэрмөрөн-аудит ХХК-ийн Захирал: Б.Мядагмаа Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com Чанарын хяналтын менежер: Д.Оюундаваа Утас: 96199692 Цахим хаяг: oyundavaa9692@gmail.com Аудитор: Ц.Мөнхтуяа Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.2.1 Залруулсан алдаа	14
4.2 .2 Төлбөрийн акт	14
4.2.3 Албан шаардлага	14
4.2.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/160
танай _____-ны № _____-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙГ
СУДЛАХ МУЗЕЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.РАГЧАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9400111.00	22952235.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,400,111.00	22,952,235.00
354	Хангамжийн материал	9,400,111.00	22,952,235.00
35410	Бичиг хэргийн материал	555,500.00	906,825.00
35420	Аж ахуйн материал	2,851,161.00	2,938,560.00
35430	Сэлбэг хэрэгсэл	615,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	415,550.00	344,050.00
35470	Бусад хангамжийн материал	4,962,900.00	18,762,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	993,484,482.79	1,022,225,952.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	993,484,482.79	1,022,225,952.47
392	Биет хөрөнгө	883,834,482.79	912,300,952.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	27,781,247.03	27,781,247.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,520,653.24	-16,286,940.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,500,000.00	22,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,500,000.00	-22,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,211,221.55	28,905,399.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,725,994.34	-4,346,521.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,088,993.00	22,661,663.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,112,880.20	-11,457,192.22
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	859,069,887.83	859,069,887.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,484,350.00	10,520,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,947,598.84	-6,052,500.17
39217	Ном	1,505,910.00	1,505,910.00
393	Биет бус хөрөнгө	109,650,000.00	109,925,000.00
39301	Програм хангамж	762,000.00	1,037,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-762,000.00	-762,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	109,650,000.00	109,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,002,884,593.79	1,045,178,187.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,309,637.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,309,637.95
413	Өглөг	00.00	1,309,637.95
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,309,637.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,002,884,593.79	1,043,868,549.52
51	Засгийн газрын хувь оролцоо	1,002,884,593.79	1,043,868,549.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	230,981,633.50	230,981,633.50
51101	Өмч: - төрийн	230,981,633.50	230,981,633.50
512	Хуримтлагдсан үр дүн	-26,551,591.54	14,432,364.19
51210	Өмнөх үеийн үр дүн	-26,551,591.54	-26,551,591.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	40,983,955.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	798,454,551.83	798,454,551.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,002,884,593.79	1,045,178,187.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	209,955,600.00	254,917,236.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	186,000.00	33,200,000.02
120	Нийтлэг татварын бус орлого	186,000.00	33,200,000.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	186,000.00	33,200,000.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	186,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	33,200,000.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	209,769,600.00	221,717,236.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,150,000.00	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,150,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	4,329,336.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	3,731,336.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	598,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	206,619,600.00	217,387,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	206,619,600.00	217,387,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	211,133,288.10	213,731,030.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211,133,288.10	213,731,030.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	209,603,558.43	209,862,757.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,206,558.61	132,562,619.00
210101	Үндсэн цалин	135,206,558.61	132,562,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,502,193.18	17,732,880.00
210201	Тэтгэврийн даатгал	12,030,012.30	12,385,015.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,415,295.27	1,370,986.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,081,836.10	1,060,499.48
210204	Ажилгүйдлийн даатгал	270,459.77	265,125.11
210205	Эрүүл мэндийн даатгал	2,704,589.74	2,651,253.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,121,860.55	37,614,565.32
210301	Гэрэл, цахилгаан	1,224,389.55	1,279,565.32
210302	Түлш, халаалт	39,565,962.00	35,735,000.00
210303	Цэвэр, бохир ус	331,509.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,522,810.99	7,923,362.00
210401	Бичиг хэрэг	1,325,349.99	1,097,386.00
210402	Тээвэр, шатахуун	918,400.00	2,367,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,217,675.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,819,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,079,061.00	1,421,401.00
2105	Нормативт зардал	838,576.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	795,076.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,262,950.00	2,484,800.00
210604	Урсгал засвар	2,262,950.00	2,484,800.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,059,700.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,059,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,500.00	4,406,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	3,062,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	83,300.00

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,500.00	75,000.00
210807	Газрын төлбөр	00.00	646,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,966,109.10	6,078,180.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,546,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,966,109.10	4,531,280.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,529,729.67	3,868,273.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	621,680.00	1,339,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	621,680.00	1,339,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	908,049.67	2,529,273.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	908,049.67	2,529,273.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,177,688.10	41,186,205.32
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	202,249.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	202,249.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-202,249.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,177,688.10	40,983,955.73

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,981,633.50	798,454,551.83	-25,123,653.28	1,004,312,532.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	230,981,633.50	798,454,551.83	-25,123,653.28	1,004,312,532.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,427,938.26	-1,427,938.26
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,981,633.50	798,454,551.83	-26,551,591.54	1,002,884,593.79
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,981,633.50	798,454,551.83	-26,551,591.54	1,002,884,593.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	230,981,633.50	798,454,551.83	-26,551,591.54	1,002,884,593.79
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	40,983,955.73	40,983,955.73
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,981,633.50	798,454,551.83	14,432,364.19	1,043,868,549.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	208,805,600.00	221,717,236.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	186,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	186,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	186,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	186,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	208,619,600.00	221,717,236.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	4,329,336.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	3,731,336.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	598,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	206,619,600.00	217,387,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	206,619,600.00	217,387,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	208,805,600.00	221,442,236.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,805,600.00	221,442,236.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,397,550.33	217,752,962.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,206,558.61	131,407,961.05
210101	Үндсэн цалин	108,126,558.61	106,726,400.00
210102	Нэмэгдэл	27,080,000.00	24,681,561.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,502,193.17	17,577,900.00
210201	Тэтгэврийн даатгал	12,030,012.30	12,369,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,415,295.26	1,302,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,081,836.10	1,041,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	270,459.77	260,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,704,589.74	2,604,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,600,598.55	37,614,565.32
210301	Гэрэл, цахилгаан	1,224,389.55	1,279,565.32
210302	Түлш, халаалт	45,044,700.00	35,735,000.00
210303	Цэвэр, бохир ус	331,509.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,534,200.00	12,165,186.00
210401	Бичиг хэрэг	1,640,000.00	1,563,196.00
210402	Тээвэр, шатахуун	918,400.00	1,947,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,264,390.00
210404	Ном, хэвлэл	00.00	6,050,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,775,800.00	1,340,000.00
2105	Нормативт зардал	730,600.00	483,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	580,600.00	483,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	740,900.00	6,068,500.00
210604	Урсгал засвар	740,900.00	6,068,500.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,059,700.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,059,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,500.00	9,640,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	8,296,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	83,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,500.00	75,000.00
210807	Газрын төлбөр	00.00	646,050.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,734,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,734,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,408,049.67	3,689,273.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	1,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,160,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	908,049.67	2,529,273.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	908,049.67	2,529,273.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	275,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	275,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	275,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	275,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	275,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-275,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,387,900.00	214,858,626.37	2,529,273.63	98.8
УРСГАЛ ЗАРДАЛ	217,387,900.00	214,858,626.37	2,529,273.63	98.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,227,900.00	213,698,626.37	2,529,273.63	98.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,806,400.00	131,407,961.05	2,398,438.95	98.2
Үндсэн цалин	106,726,400.00	106,726,400.00	0.00	100.0
Нэмэгдэл	27,080,000.00	24,681,561.05	2,398,438.95	91.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,577,900.00	17,577,900.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	12,369,600.00	12,369,600.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	1,302,100.00	1,302,100.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,041,700.00	1,041,700.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	260,400.00	260,400.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	2,604,100.00	2,604,100.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,640,400.00	37,614,565.32	25,834.68	99.9
Гэрэл, цахилгаан	1,305,400.00	1,279,565.32	25,834.68	98.0
Түлш, халаалт	35,735,000.00	35,735,000.00	0.00	100.0
Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	11,144,600.00	11,114,600.00	30,000.00	99.7
Бичиг хэрэг	1,200,000.00	1,208,910.00	-8,910.00	100.7
Тээвэр, шатахуун	1,251,300.00	1,251,300.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,273,300.00	1,264,390.00	8,910.00	99.3
Ном, хэвлэл	6,050,000.00	6,050,000.00	0.00	100.0

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,370,000.00	1,340,000.00	30,000.00	97.8
Нормативт зардал	483,800.00	483,800.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	483,800.00	483,800.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	5,804,700.00	5,729,700.00	75,000.00	98.7
Урсгал засвар	5,804,700.00	5,729,700.00	75,000.00	98.7
Томилолт, зочны зардал	259,700.00	259,700.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	259,700.00	259,700.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,510,400.00	9,510,400.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,489,100.00	8,489,100.00	0.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	83,300.00	83,300.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	75,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	323,000.00	323,000.00	0.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,160,000.00	1,160,000.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	1,160,000.00	1,160,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,160,000.00	1,160,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,387,900.00	214,858,626.37	2,529,273.63	98.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	217,387,900.00	214,858,626.37	2,529,273.63	98.8
Орон нутгийн төсвөөс	217,387,900.00	214,858,626.37	2,529,273.63	98.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,329,336.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,329,336.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,329,336.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,050,586.00
210401	Бичиг хэрэг	354,286.00
210402	Тээвэр, шатахуун	696,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	338,800.00
210604	Урсгал засвар	338,800.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,000.00
210807	Газрын төлбөр	323,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1734900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,734,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,329,336.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,329,336.00

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,731,336.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	598,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад санхүүгийн тайлагнал болон шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатны хяналтыг, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музей 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музей нь өөрийн аймгийн угсаатан, ястны онцлог, өвөрмөц зан заншил, түүх, соёлын дахин давтагдашгүй үзмэрээр сан хөмрөгөө арвижуулж баяжуулах, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, нийтэд дэлгэн үзүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг Хөвсгөл аймгийн Засаг даргын харъяа байгууллага юм .

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын газраас 2021 онд тус байгууллагад хяналт, шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музей 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 211.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42.3 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар нэмэгджээ.

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансанд тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая. төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	0	0
Бараа материал	9.4	23	13.6
Үндсэн хөрөнгө	993.5	1022.2	28.7
Нийт хөрөнгө	1002.9	1045.2	42.3
Өр төлбөр	0	1.3	1.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1002.9	1043.9	41.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1002.9	1045.2	42.3

Хөвсгөл аймгийн орон нутгийг судлах музейн үзмэрийн сан хөмрөгт байгаа 4000 гаруй үзмэрийн 30 гаруй хувь нь дэглэгдэж, бусад үзмэр нь байр талбайн хүрэлцээ муу учраас сан хөмрөгт хадгалагдаж байдаг тул түүх соёлын давтагдашгүй, үнэт үзмэрийг олон нийтийн хүртээл болгож, сурталчлан таниулах зорилгоор 2021 онд “Хөвсгөлийн музейн дээжис” номыг хэвлүүлэн, аймгийн газар нутгийн макетыг шинэчлэн хийлгэсэн, сурталчилгааны том самбар байршуулсан зэргээс шалтгаалан бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 13.6 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,045.2 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 28.7 сая төгрөг болж өссөн нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны

өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, үлдэгдэл өртөг нь "0" болсон боловч цаашид ашиглах боломжтой 60 нэр төрлийн 110.4 сая төгрөгийн анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж, өртгийг шинэчлэн 33.2 сая төгрөгөөр тогтоосон, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон 3.5 сая төгрөгийн анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж данснаас хассан нь нөлөөлсөн байна. Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүн 41.0 сая төгрөгөөр өөрчлөгджээ.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.2		-0.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1.2	33.20	32.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	206.6	217.40	10.8
Нэмэлт санхүүжилтийн орлого	2.0	4.30	2.3
Үйл ажиллагааны орлогын дүн	209.9	254.9	45.0
Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	152.7	150.30	-2.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41.1	37.70	-3.4
Хангамж, бараа материалын зардал	4.5	8.00	3.5
Нормативт зардал	0.8		-0.8
Эд хогшил, урсгал засварын зардал	2.3	2.60	0.3
Томилолт		1.10	1.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.2	4.40	4.2
Бараа үйлчилгээний бусад зардал	8.0	6.10	-1.9
Урсгал шилжүүлэг	1.5	3.90	2.4
Үйл ажиллагааны зардлын дүн	211.0	214.1	3.1
Үйл ажиллагааны үр дүн	-1.1	40.80	41.9
Үйл ажиллагааны бус үр дүн	-0.2	0.20	0.4
Нийт үр дүн	-1.3	41.0	42.3

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 45.0 сая төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Энэ нь тус байгууллагын 2021 оны төсөв өмнөх оноос 10.8 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсантай холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, үйлчилгээний зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музей нь 2021 оны төсвийн төслийг 207.7 сая төгрөгөөр төлөвлөж, Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 194.2 сая төгрөгөөр батлан, 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тодотгож, 1.9 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 217.4 сая төгрөгийн төсөв баталснаас 217.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 217.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 214.9 сая төгрөгийг зарцуулж 2.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 214.9 төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар Ханх суманд түүх, соёлын дурсгалын улсын тооллогоор ажиллах зардалд 2.0 сая төгрөг, аймгийн Засаг даргын 2021 оны А/609 дүгээр тушаалаар соёлын ажилтны сургалтын зардалд 1.7 сая төгрөг, нийт 3.7 сая төгрөгийг хүлээн авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч нэгтгэн, дүгнэхэд зайлшгүй зардлаас бусад төсөвт зардалд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн А/108 дугаар тушаалаар батлагдсан шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийн дагуу шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 75.2 сая төгрөгийн 13 мэдээллийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт-5 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	6.3	2	6.3	-	-	100.0
Акт	1	0.2	1	0.2	-	-	100.0
Нийт дүн	3	6.5	3	6.5	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Музейн сан хөмрөгийн тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тавигдаагүй болно.

4.2.3 Албан шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 заалтад заасан зайлшгүй шаардлагатайгаас бусад төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: 2021 онд хийсэн музейн сан хөмрөгийн тооллогод хамрагдсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгагдсан хөрөнгөтэй тулгалт хийж, тооллогын үр дүнг баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: 2021 онд хийсэн музейн сан хөмрөгийн тооллогод хамрагдсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгагдсан хөрөнгөтэй тулгаж, тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2 Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад ном бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Номыг бараа материал, үндсэн хөрөнгийн алинд бүртгэхийг тогтоож, ангиллыг зөв болгож бүртгэх

3 Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр толилуулсан санхүүгийн байдлын тайланд 1.3 сая төгрөгийн өглөг шинээр бүртгэгдсэн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалт” төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг мөрдөж ажиллах

4 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Автомашины доторлогоог машинаас тусад нь үндсэн хөрөнгөөр бүртгэсэн нь УСНББОУС-д заасан хөрөнгийн шалгуурыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шалгуур хангаагүй хөрөнгийг данс, бүртгэлээс хасах, цаашид шалгуур хангасан хөрөнгийг бүртгэлд тусгаж байх

5 Мөнгөн зарлагын гүйлгээг баримтжуулахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн зарлагын гүйлгээ нь татварын нэгдсэн системээс гарах төлбөрийн баримтаар дэмжигдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн зарлагын гүйлгээг хийхдээ татварын нэгдсэн системээс гарах төлбөрийн баримтаар баримтжуулсны дараа хийх

6 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 75.2 сая 13 мэдээллийг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, бүрэн байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музей	4	2.4							4	2.4
Дүн		4	2.4							4	2.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		3	6.8					1	6.8	2	-
Дүн											
Нийт дүн		7	9.2					1	6.8	6	2.4



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 сарын 25 өдөр

№ 14/А2950433/ТӨА-2022/
226/Т.А-СМА-ТМЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад зардлаас 9,300,000/Есөн сая гурван зуун мянга/төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж, буцаан төвлөрүүлэхээс 2,500,000/Хоёр сая таван зуун мянга/ төгрөгийг буцаан төвлөрүүлж 6,800,000/Зургаан сая найман зуун мянга/ төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Орон нутгийг судлах музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Рагчаа, нягтлан бодогч Д.Балжинням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  Б.МЯДАГМАА

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЭДТГ-ын байрны А корпус 3 давхар 303 тоот, утасны дугаар: 7038 4043